



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 05 сарын 01 өдөр

Дугаар А/аар

Мандалговь

Г Бэлчээрийн хөнөөлт үлийн цагаан
оготонотой тэмцэх ажлыг зохион
байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "а", Байгалийн ургамлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дахь заалт, Ургамал хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны төрийн нарийн бичгийн даргын 2018 оны А-31 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Бэлчээрийн мэрэгч амьтан үлийн цагаан оготнотой тэмцэх ажлыг улсын төсвийн хөрөнгөөр энгийн механик аргаар 50,0 мян/га-д, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр микробиологийн аргаар 22,5 мян/га-д 2018 оны 05 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн 45 хоногт багтаан явуулсугай.

Хоёр.Хамрагдах сумдын нэр, тэмцэх бэлчээрийн талбайн хэмжээг хавсралтаар баталсугай.

Гурав. Уг арга хэмжээнд орон нутгаас санхүүгийн дэмжлэг үзүүлж, зохион байгуулах ажлын хэсгийг байгуулан, голомт бүхий малчин өрх бүрээс 1 малчныг ажиллуулан, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгааг нарийн чанд мөрдүүлж, хариуцлагатай зохион байгуулахыг холбогдох сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

Дөрөв. Ажлын явцад байнгын хяналт тавьж, илэрсэн дутагдал, зөрчлийг цаг алдалгүй арилгаж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газар/Ш.Төрбат/-т үүрэг болгосугай.

Тав. Сумдын Засаг дарга нартай гэрээ байгуулан, тэмцэх талбай болон санхүүжилтийг хуваарилах, сургалт зохион байгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, гэрээний биелэлтэд хяналт тавих, тайлан мэдээг хугацаанд нь холбогдох яам, газарт хүргүүлэн, аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулахыг ХХААГ /Б.Мөнхжаргал/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О. БАТ-ЭРДЭНЭ

0200585

Аймгийн Засаг даргын 2018 оны 05 дугаар сарын
01-ний өдрийн 4/ДС тоот захирамжийн хавсралт



Бэлчээрийн үлийн цагаан оготготой тэмцэх арга хэмжээний хуваарь

Д/д	Сумдын нэр	Үлийн цагаан оготно тархсан талбай мян/га	Тэмцэх талбайн хэмжээ мян/га
1	Эрдэнэдалай	345,9	10,0
2	Адаацаг	147,6	10,0
3	Дэлгэрцогт	109,5	10,0
4	Дэрэн	280,3	17,0
5	Цагаандэлгэр	256,0	17,0
6	Луус	23,7	3,5
7	Сайхан-Овоо	3,0	1,0
8	Сайнцагаан	49,1	4,0
	Нийт	1215,2	72,5

